

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**2024 оны 4 дүгээр
сарын 22-ны өдөр

№ 12

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76.1 дүгээр зүйлийн 76.1.11-т Төлөөлөн удирдах зөвлөл компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 31.3 дугаар зүйлийн 31.3.5-д Банкны төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 29.2.6, 29.2.7-д заасан асуудлаар дүгнэлт гарган хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.13-т Төлөөлөн удирдах зөвлөл Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахаар заасныг тус тус үндэслэн, **ИЙНХҮҮ:**

- ТОГТООХ НЬ:** 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ХААН Банкны санхүүгийн тайланд аудит хийсэн “Прайсуотерхаускуперс Аудит” ХХК-ийн аудитын тайланг хүлээн авсугай.
- ТОГТООХ НЬ:** ХААН Банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланг баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Тайланг эцэслэн батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум
Д.Хулаа
Харада Ясүнари
Ц.Баатарсайхан







Кисауро Иший




Жон Ло



А. Гамир



Аарт Йонгеянс



Б.Амурсанаа

2024 оны 4 дүгээр
сарын 22-ны өдөр

No 13

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 31.3 дугаар зүйлийн 31.3.1-т Банкны төлөөлөн удирдах зөвлөл нь банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.1-т Төлөөлөн удирдах зөвлөл Банкны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлахаар заасныг тус тус үндэслэн, **ИЙНХҮҮ:**

- 1. ТОГТООХ НЬ:** ХААН Банкны гүйцэтгэх захирлаас шинэчлэн танилцуулж буй Банкны зохион байгуулалтын шинэчилсэн бүтэц (Хавсралт №1)-ийг 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхлэхийг санал нэгтгэйгээр баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ



Харада Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабуро Иший

Жон Ло



А.Тамир

Аарт Йонгоянс

Б.Амарсанаа

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр
сарын 22-ны өдөр

№ 16

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсгийн 76.1.3 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 7 тоот тогтоол болон 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 11 тоот тогтоолын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны удирдлагаас танилцуулсан “ХААН Банкны олон нийтэд анх удаа хувьцаагаа арилжаалах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар санал нэгтгэйгээр шийдсэн болохыг тус тус үндэслэн, **ИЙНХҮҮ:**

1. **ТОГТООХ НЬ:** “БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 36.1-Д ЗААСАН ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЭХЭД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-г энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
2. **ТОГТООХ НЬ:** Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ



Харада Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабуро Иший

Жон Ло



Тамир

Аарт Понгоянс

Б.Амарсанаа